

Орхон аймгийн Ардчилсан намын хорооны
2020 оны 06 дугаарсарын 20-ны өдрийн
06 дугаар тогтоолын хавсралт



ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Монгол хүн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол Улсаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

- Монгол хүний эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах хувь хүний эрх чөлөө;
- Хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглал;
- Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн үнэт зүйлээ болгон тунхагласан АРДЧИЛСАН НАМ 2020 оны Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд **“ӨРХИЙГ ДЭМЖСЭН – ӨСӨЛТИЙН БОДЛОГО”** мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.



НЭГ. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ

- 1.1 Ерөнхий боловсролын сургуулиудын сурах орчин нөхцлийг сайжруулж, хотын төв болон захын хорооллын сургуулиудын сургалтын чанарын ялгааг арилгана.
- 1.2 Цэцэрлэг, сургуулийн нэг ангийн хүүхдийн тоог 30-аас хэтрүүлэхгүй байх стандартыг хэрэгжүүлнэ.
- 1.3 “Ахлах сургууль” хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлж, төгсөх ангидаа мэргэжил сонгодог, зарим мэргэжлийг эзэмшүүлдэг системд шилжүүлнэ.
- 1.4 Боловсролын салбарт “Ногоон хөгжил, ногоон ирээдүй” хөтөлбөр хэрэгжүүлж хөдөлмөр зуслангийн хэлбэрээр зохион байгуулна.
- 1.5 Багшийн хөгжлийн үнэлгээ-урамшууллын систем боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.6 Эрдэнэт хотын гэр хороололд олон нийтийн номын сан байгуулна.
- 1.7 Эрдэнэт хотын иргэд ӨЭМТ-ийн харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээг авдаг болгоно.
- 1.8 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг эмнэлэгийн чанар, стандартад нийцсэн зориулалтын байраар үе шаттайгаар хангана.
- 1.9 Эрүүл мэндийн байгууллагын хүртээмжийг стандартын шаардлагад нийцүүлэн сайжруулж, эмнэлэгийн орны тоог нэмэгдүүлнэ.
- 1.10 Эрүүл мэндийн цахим хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлж, аймгийн хэмжээний нэгдсэн мэдээллийн сантай болгоно.
- 1.11 Олон улсын түвшний оношилгоог орон нутагтаа хийж, “Медипасс” оношилгооны төвийн ажлыг БОЭТ-ийн үйл ажиллагаатай уялдуулан, гадаадад оношлуулж эмчлүүлэх зардлыг хэмнэж, мөнгөний урсгалыг орон нутагтаа үлдээх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.12 Иргэдийг хөдөлгөөний хомсдол, сэтгэцийн эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл, төрөл бүрийн донтолт, хамаарлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй ажлуудыг дэмжиж, хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 1.13 Хүүхэд, өсвөр насныханд зориулсан сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ явуулах, мэргэжлийн чадамжийг хөгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.14 Эрүүл мэндийн удирдах, хянах байгууллагууд, улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, даатгалын байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах замаар давхардал, чирэгдэл, хүнд суртлыг арилгаж, эрүүл мэндийн үйлчилгээний нээлттэй, хөнгөн шуурхай, цогц байдлыг хангах, хянах тогтолцоог боловсронгуй болгоно.
- 1.15 Хүүхдээ асран хамгаалж байгаа гурав хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хүүхдээ өсгөсөн жилийн үнэлэмжийг сайжруулна.
- 1.16 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлогыг шинэчилж, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж, төлөвших хөтөлбөр, заах аргыг хөгжүүлнэ.
- 1.17 Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын асуудалд анхаарч, хүүхдийн эрхийн зөрчил, хүчирхийллийг бууруулах, хөгжил оролцоог нь дэмжих, багш, эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх ажлыг дэмжин, хүүхдэд ээлтэй, эрүүл аюулгүй сургалтын орчин бүрдүүлэхэд анхаарна.


У. Б. Байраг
8428916 УНТ0921

Орхон аймгийн
Хүнс, хөдөө аж ахуйн
Хүндэтгэлийн
Төв
811714333
6113073 6117116

- 1.18 Хүүхдийг цахим мэдээллийн халдлагаас хамгаалах нөхцлийг бүрдүүлнэ.
- 1.19 Тусгай хэрэгцээт хүүхдийн тасралтгүй боловсрол эзэмшихийг нь дэмжинэ.
- 1.20 Хүүхдийн болон гэр бүлийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудад бодлогын дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 1.21 Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг бүрэн шийдвэрлэн эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.
- 1.22 Ахмадын өдөр өнжүүлэх төвүүдийг бий болгож хөгжүүлнэ.
- 1.23 Гэр бүлийн гишүүн бүрд гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.
- 1.24 Иргэдээ зээлийн хөнгөлттэй нөхцлөөр хувийн орон сууцтай болгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.25 Хот байгуулалт, барилга, нийгэм, соёлын байгууламжийн төлөвлөлтөд нийт иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийг бий болгоно.
- 1.26 Ажлын цагийн уян хатан зохицуулалт, зайнаас болон цахим орчинд хөдөлмөрлөх боломж бүхий ажлын байрыг дэмжинэ.
- 1.27 Хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэр (цагийн ажил, аутсорсинг, сүлжээний борлуулалт, ажиллах хүч нийлүүлэх үйлчилгээ г.м.)-ийг хүлээн зөвшөөрнө.
- 1.28 Гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх (санхүүжилт, сургалт, мэдээлэл, г.м.).
- 1.29 Нийгмийн халамжийн салбарт сайн дурын ажлыг дэмжих, урамшуулах тогтолцоог бүрдүүлнэ.
- 1.30 Малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.
- 1.31 Ипотекийн зээлийг үргэлжлүүлнэ. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг ипотекийн зээлтэй уялдуулна.
- 1.32 Залуу гэр бүл, гэр хорооллын айл өрхүүд, бусад зорилтот бүлгийн өрхийг түрээсийн орон сууцаар хангах ажлыг эхлүүлнэ.

ХОЁР.ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ


- 2.1 Эрдэнэт хотын бонд гаргах эрх зүйн орчныг бий болгож, санхүүжилт татаж, хөгжлийн томоохон төслүүдийг санхүүжүүлнэ.
- 2.2 Экспортод чиглэсэн бизнест эрх зүйн хувьд зөвшөөрөгдсөн, боломжит дэмжлэгүүдийг үзүүлнэ.
- 2.3 Уул уурхайн нөхөн сэргээх шаардлагатай газруудад үйл ажиллагааг нь санхүүжүүлэх зорилго (нөхөн сэргээлтийн дэнчин, бонд) бүхий хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, иргэд, орон нутаг, олон нийтийн оролцоо, олон улсын байгууллагуудтай хамтран ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, байгаль орчныг нөхөн сэргээнэ.



- 2.4 Уул уурхай, хөдөө аж ахуй, зам, барилгын тоног төхөөрөмж ба бусад төрлийн металл/зэс/, резинэн хийцийн эд ангийн үйлдвэрлэлийг дэмжсэн цогц төлөвлөгөө хэрэгжүүлнэ.
- 2.5 Орон нутгийн төрийн худалдан авалтын үйл ажиллагааг орон нутагтаа сонгон шалгаруулдаг, дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг тогтолцоонд шилжинэ.
- 2.6 Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуйг бодлогоор дэмжин, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын ногоогоор жилийн турш хангана.
- 2.7 Хувийн хэвшлийн хийх боломжтой ажлуудыг төр хийдэггүй байх зарчмыг баримталж, Эрдэнэт хотын хэмжээнд хувийн хэвшлийг татвар, санхүүгийн оновчтой бодлогоор дэмжинэ.
- 2.8 Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулдаг төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, компанид бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа орон нутгийн аж ахуйн нэгжүүдэд давуу эрх олгох тогтолцоог бий болгоно.
- 2.9 Жаргалант сумыг түшиглэн “Экологийн цэвэр хүнс” хөтөлбөр хэрэгжүүлж, өвлийн хүлэмж, зoorь барих болон лаазалсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хувийн хэвшлийн санаачилгыг дэмжин хөгжүүлнэ.
- 2.10 Өвлийн спорт, амралтын цогцолбор төв байгуулна.
- 2.11 Оюутан залуучуудыг дэмжиж, ажлын байр бий болгосон аж ахуйн нэгжүүдийг бодлогоор дэмжинэ.
- 2.12 Залуусын бизнес эрхлэлт, инноваци шингэсэн гарааны бизнесийг дэмжих бодлогыг оновчтой болгож, үүссэн дэд бүтцийг өргөжүүлж, сайжруулна.
- 2.13 Өрхийн болон жижиг дунд үйлдвэрлэлийн зориулалттай зээлийн сан, хүртээмжийг нэмэгдүүлэх замаар шинэ ажлын байр бий болгоно.
- 2.14 Аялал жуулчлалын бизнесийг дэмжиж, урамшуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын бүс нутаг болох зорилтыг хэрэгжүүлнэ.
- 2.15 Гадаадын жуулчдад зориулсан дижитал үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, Эрдэнэт хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон хэлээр хүргэдэг болно.
- 2.16 Жуулчдад зориулсан аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгож, аюулгүй байдлыг хангах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.17 “Эрдэнэт хот ИТ парк” төлөвлөлтийн эхлэнэ.
- 2.18 Бараа материал, шууданилгээмжийн хүргэлтийн ложистик төвүүд, цахим дэлгүүрийн сүлжээг хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулна.
- 2.19 Ажлын байрыг хадгалж, иргэн, бизнесээ дэмжсэн тусгай хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 2.20 Ажиллах хүчийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах, ажлын байр олноор бий болгохыг нэн тэргүүний зорилт гэж үзэн шинэ ажлын байрыг бий болгох бүтээн байгуулалт, бизнесийн төслүүдийг бүх талаар дэмжиж хөгжүүлнэ.



ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

- 3.1. Хот төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хяналттай хэрэгжүүлнэ.
- 3.2. Эрдэнэт хотод бүсчлэл тогтоож, иргэдийн амьдрах орчны стандартыг бүсчлэлд тулгуурласан байдлаар боловсруулж, хэрэгжүүлнэ.




ГУРАВ. ЭЗЭН МОНГОЛ

- 3.1. Хот төлөвлөлтийг ил тод, нээлттэй болгож, олон нийтийн хяналттай хэрэгжүүлнэ.
- 3.2. Эрдэнэт хотод бүсчлэл тогтоож, иргэдийн амьдрах орчны стандартыг бүсчлэлд тулгуурласан байдлаар боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.3. Гэр хорооллын инженерийн шугам сүлжээний мэдээлэл үйлчилгээний төв байгуулна.
- 3.4. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэлтийг хариуцлагажуулна.
- 3.5. Барилгажилтыг дэмжихгүй байршлуудыг шинэчлэн тодорхойлж, уг байршилд шинээр байшин барилга бариулахгүй байх шийдвэр гаргаж, иргэдэд танилцуулна.
- 3.6. Гэр хорооллын иргэд төвлөрсөн дулаан, цэвэр, бохир усны хангамжид холбогдсон амины орон сууцтай болохыг дэмжинэ.
- 3.7. Гэр хорооллын цэвэр усны үнийг орон сууцны хэрэглэгчдийн түвшинтэй ижил болгож бууруулах, усны эх үүсвэрийн найдвартай ажиллагааг дээшлүүлнэ.
- 3.8. Замын дагалдах дэд бүтэц болох ус зайлуулах шугам, гэрэлтүүлэг, ногоон байгууламжийг стандартын дагуу барина.
- 3.9. Эрдэнэт хотод буй авто зогсоолын тоог дорвитой нэмэгдүүлэх, хот хоорондын автовокзалтай болно.
- 3.10. Хотын гудамжийг иргэд, аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийж, тохижуулж, өөрсдийн нэрээр нэрлүүлэх боломжтой болгоно.
- 3.11. Үерийн далан сувгуудыг шаардлагатай газруудад нэмж барих, сайжруулах ажлыг жил бүр үе шаттай хийнэ.
- 3.12. Гэр хороололд “Халуун ус” хөтөлбөрийг иргэдийн оролцоотой, санхүүгийн шинэ арга хэлбэрийг ашиглан хэрэгжүүлнэ.
- 3.13. Эрдэнэт хотын зарим гудамжуудыг явган зорчигчид зориулагдсан, автомашингүй гудамж болгоно.
- 3.14. Авто замын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд дугуйн болон явган замыг шийддэг болгоно.
- 3.15. Гэр хорооллын гудамж хоорондын авто замыг шинэчлэх ажлыг үргэлжлүүлнэ.
- 3.16. Гамшгийн үед ашиглах орц, гарц, замыг чөлөөлж, явган зорчигчийн зам, талбайг орхигдуулсан, хаасан иргэн, хуулийн этгээдэд оногдуулах хариуцлагыг өндөржүүлнэ.
- 3.17. Зуслан болон амралт, зугаалгын бүсүүдэд явган хүний болон унадаг дугуйн дэд бүтцийг байгуулна.
- 3.18. Хотын төв замын ачааллыг бууруулах чиглэлээр шинэ замыг төлөвлөн, хотын нэг захаас нөгөөд очих хурдыг нэмэгдүүлнэ.
- 3.19. Нийтийн тээврийн салбарт бүтцийн өөрчлөлт хийж, тээврийн хэрэгслийг олон сонголттой (том оврын автобус, микробус гэх мэт) болгож, парк шинэчлэлт хийнэ.
- 3.20. Нийтийн тээврийн үйлчилгээнд шаардлага хангасан тээврийн хэрэгсэлтэй иргэдийг өөрсдийнх нь хүсэлтээр татан оролцуулж, бодлогын дэмжлэг үзүүлнэ.
- 3.21. Дугуйн прокат, ухаалаг үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 3.22. Залуу зохион бүтээгчдийн төв байгуулна.




- 3.25. Гэр хорооллыг өвлийн цагт цахилгаанаар халаах чадвартай болгох үүднээс цахилгаан дамжуулах чадамжийг нэмэгдүүлнэ.
- 3.26. Эрдэнэт хотод цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх цэгүүдийг хувийн хэвшлийн оролцоон дээр тулгуурлан байгуулна.
- 3.27. “Жорлонгоо өөрчилье” төслийг эхлүүлэх, Хот-Иргэн хоёрын хамтын механизм хөгжүүлэн, гэр хорооллын айл өрхийн жорлонг шинэчилж, жорлонгоос үүдэх өвчлөл, бохирдолыг бууруулна.
- 3.28. Гэр хорооллын 500 айлыг бие даасан бохирын системд холбож, хөрс усны бохирдлыг багасгана.
- 3.29. Хог таталтын мененжментийг төр хувийн хэвшлийн оролцоотой цоо шинэ тогтолцоог бий болгоно.
- 3.30. Машинтай хувь хүмүүстэй гэрээ байгуулж эзэнгүй болон гэр хорооллын хог ачилт, бохирыг татан зайлуулах ажлыг зохион байгуулж цэмцгэр хотыг бий болгоно.
- 3.31. Дулаан, усны дамжуулалтын алдагдлыг бууруулах зорилгоор газар доорх дундын хоолой, айл өрх бүрт ус, цахилгааны хэрэглээгээ (өдөр, сарын хэрэглээ, мөнгөн дүн г.м) хянах боломжийг олгох электрон дэлгэцтэй ухаалаг метрийг суурилуулна.
- 3.32. Усыг дахин ашиглах, “Саарал ус”-ыг “Эрдэнэт үйлдвэр”-т ашиглах технологийг нэвтрүүлнэ.
- 3.33. Сэргээгдэх эрчим хүч, байгаль орчинд ээлтэй дэд бүтцийн шийдлүүдийг хөнгөлөлттэй санхүүжилтээр дэмжинэ.
- 3.34. Хөдөлмөр зуучлалын төвийг бий болгож, ажилгүй иргэдийг аж ахуйн нэгжүүдэд ажилд зуучилж, байршуулдаг тогтолцоог бий болгоно.
- 3.35. Ногоон хөгжлийг дэмжих бодлогын хүрээнд мод тарих, ойн сан хамгаалах, усан сан, парк байгуулах, ойн төгөл, цэцэрлэгт хүрээлэн байгуулах иргэдийн бүлэг, нөхөрлөлийг бодлогоор болон урамшуулал хөнгөлөлтийн олон талт хэлбэрээр дэмжинэ.
- 3.36. Иргэдийн хүнсний хэрэгцээгээ өөрөө хангах, хүлэмжийн аж ахуй эрхлэх санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 3.37. Малыг тооноос илүү чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- 3.38. Малын бэлчээр, усалгаа, тэжээл, вакцин хэрэглээний аюулгүй байдлыг ханган үйлдвэрлэлийн аргаар бэлтгэсэн мах, махан бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, түүний хяналт мэдээллийн тогтолцоог бий болгоно.
- 3.39. Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.
- 3.40. Газар тариаланг урамшуулах бодлогыг шинэчилнэ. Үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, аж ахуйг сэргээн хөгжүүлж, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- 3.41. Ургамал хамгаалах химийн бодис бордоо болон био бэлдмэлийн ухаалаг хяналтыг бий болгоно.



- 3.39. Гахай, шувуу, зөгий, загас үржүүлгийн аж ахуй эрхлэх, хөгжүүлэх санаачилгыг дэмжинэ.
- 3.40. Газар тариаланг урамшуулах бодлогыг шинэчилнэ. Үрийн аж ахуйн системийг боловсронгуй болгож, аж ахуйг сэргээн хөгжүүлж, хөрс, цаг уурын онцлогт тохирсон, баталгаат сортын үрийн хангамжийг нэмэгдүүлнэ.
- 3.41. Ургамал хамгаалах химийн бодис бордоо болон био бэлдмэлийн ухаалаг хяналтыг бий болгоно.
- 3.42. Газар тариалангийн бүс нутагт услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, тариалан эрхлэгч, хүнсний ногоо тариалагчдыг бодлогоор дэмжинэ.
- 3.43. Экспортод чиглэсэн өндөр ашиг шимт эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлнэ.
- 3.44. Дотоодын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 3.45. Орон нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон ургамлын аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлж, импортыг орлох органик брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал санаачилгыг бүх талаар дэмжинэ.
- 3.46. Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлж, орчин үеийн техник хангамжийн түвшнийг дээшлүүлнэ.
- 3.47. Эрдэс болон органик гаралтай бордооны дотоодын үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлж, хангамжийг нэмэгдүүлнэ.
- 3.48. Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортыг орлох чанартай, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 3.49. Айл, хөрш, гудамжаараа нэгдэн төлөвлөлт хийж, инженерийн дэд бүтцэд бүрэн холбогдсон, амины орон сууц болгон дахин төлөвлөх ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлж, амьдран суух байшингаа барихад нь урт хугацаатай, хүү багатай, орон сууцны ипотекийн зээлээр санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллана.
- 3.50. Хөрш аймаг сумдтай хамтран ажиллах, шинэ суурьшлын бүс, нийгмийн дэд бүтцийн ашиглалт хүртээмжийг нэгдсэн төлөвлөлт гарган хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. ХУУЛЬТАЙ МОНГОЛ



- 4.1. Эрдэнэт хотын менежментийг гадаадын тэргүүлэх хотуудын түвшинд хүргэж, гүйцэтгэл, бүтээмжийг эрс нэмэгдүүлнэ.
- 4.2. Нийтийн албан тушаалтнуудын гаргасан шийдвэр, үйл ажиллагаанд үнэлгээ хийж, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага тооцдог болно.
- 4.3. Эрдэнэт хотын удирдлагын шийдвэр гаргалтанд мэргэжлийн холбоод, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагууд, иргэдийн сонирхлын бүлгүүдийн оролцоог хангана.
- 4.4. Эрдэнэт хотын удирдлага улирал тутам үйл ажиллагааны тайланг иргэдэд тавьдаг болно.
- 4.5. Төрийнзарим үйлчилгээг иргэдэд цахимаар хүргэж, үйлчилгээг онлайнаар үзүүлнэ.
- 4.6. Төрийн үйлчилгээнд иргэдээс шаарддаг бичиг баримтыг цөөрүүлнэ.
- 4.7. Бүх төрийн байгууллагуудын үзүүлж буй үйлчилгээний чанар, үйлчлүүлж буй иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээг хөндлөнгийн мэргэжлийн судалгааны



- байгууллагатай хамтран жил бүр тогтмол хийж, үр дүнд нь үндэслэн үйл ажиллагаандаа тасралтгүй сайжруулалт хийнэ.
- 4.8. Гэр хороололд банкны АТМ, 24 цагийн эмийн сан, яаралтай түргэн тусламж зэрэг үйлчилгээг ажиллуулна.
 - 4.9. Иргэдийн оролцоог хангах чиглэлээр дүрэм журмыг боловсронгуй болгож, үр нөлөөтэй тогтолцоо бий болгоно.
 - 4.10. Хотын хөгжилд оруулах иргэдийн санал, хүсэлт, санаачилгыг бүртгэх, хүлээн авах, бодлогод тусгах нэгдсэн цахим платформ бий болгоно.
 - 4.11. Хот тохижилтын асуудлаар шийдвэр гаргахдаа иргэдийн саналд үндэслэдэг болно.
 - 4.12. Эрдэнэт хотын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлэх асуудалд иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын саналыг авч, тусгадаг болно.
 - 4.13. Сууц өмчлөгчдийн холбоо(СӨХ)-г бүтэц зохион байгуулалтын шинэ хэлбэрт шилжүүлж, менежментийг нь оновчтой болгох асуудлыг иргэдийн санал санаачлагад тулгуурлаж хэрэгжүүлнэ.

ТАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН МОНГОЛ

- 5.1. Хүүхдэд ээлтэй хот болох цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- 5.2. Хотын төвийн газар эзэмшиж буй аж ахуйн нэгж, иргэдэд хотын стандартын дагуу тохижилт хийх, ногоон байгууламж байгуулах, иргэдийн зорчих боломжийг хангах шаардлага тавьж, хэрэгжүүлнэ.
- 5.3. Гадна талбай, ойр орчмоо тохижуулсан аж ахуйн нэгж, албан байгууллагад орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлж, тохижуулсан газрыг нь эзэмшүүлэх тогтолцоог бий болгоно.
- 5.4. Эрдэнэт хотын гэр хорооллын болон хотын гудамжуудыг бүрэн камержуулах, гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх замаар гэмт хэргийн гаралтыг бууруулж, хяналтыг сайжруулна.
- 5.5. Цагдаагийн байгууллагын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хөдөлгөөнт эргүүлийг 2 дахин нэмэгдүүлнэ.
- 5.6. Өдөр тутмын амьдралд эрсдэл учруулж болохуйц объект, барилга байгууламж болон бусад эрсдлийг мэдээллэх платформ ажиллуулна.
- 5.7. Эрдэнэт хотын хүнсний аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр стандартуудыг чангатгаж, хүнсэн дэх хорт бодисыг хэмждэг лаборатори байгуулна.
- 5.8. Хүнсний аюулгүй байдлыг хангах үүднээс Эрдэнэт хот орчмын газарнутагт органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд сертификат олгож, хоол хүнсний нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгоно.
- 5.9. Камерийн хяналтын сүлжээг цогцоор бий болгож, мэдээллийн баазад ААНБ ын болон тээврийн хэрэгслийн хяналтын төхөөрөмжийг хамтран ашиглаж, гэмт хэрэг зөрчил, өмчийн эсрэг асуудлыг шийдвэрлэхэд ашиглана.
- 5.10. Үүсмэл цагаан шороог эдийн засгийн эргэлтэнд оруулж, "Эрдэнэт хөгжил" сан байгуулах.
- 5.11. "Ногоон бүс" хөтөлбөр (Эрдэнэт голыг сэргээх, хамгаалах, арчлах зорилгоор голын эрэг дагасан ногоон бүс, ойжуулалт хийх) хэрэгжүүлнэ.



- 5.12. Хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хөрсний чанарыг сайжруулах зорилгоор гэр хорооллын айл өрх бүрт хашаандаа мод тарих, хүлэмжийн аж ахуй эрхлэхэд санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх тогтолцоог бий болгоно.
- 5.13. Байгалийн давагдашгүй хүчин зүйл, болзошгүй гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, эрсдлийг даван туулах чадавхийг сайжруулах хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.14. Хотын бүсэд ургадаг, харшил үүсгэгч шарилж, зэрлэг ургамлыг устгаж, иргэдийн эрүүл таатай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.
- 5.15. Гүний усны ашиглалтын хязгаарлан, гадаргын усны хуримтлал бий болгох, усыг цэвэршүүлэх технологи нэвтрүүлж газар тариалангийн усалгаанд ашиглана.
- 5.16. Гэр хорооллын оршин суугчдын түлшний хэрэглээг аюулгүй болгох, агаар дахь хорт хийн хэмжээг эрүүл ахуйн шаардлага стандартын хэмжээнд хүртэл багасгах, халаалтын шинэ технологийг дэмжин агаарын бохирдолыг эрс багасгана.
- 5.17. Эрчим хүч, аж үйлдвэрийн салбар, гэр хорооллын нүүрсний хэрэглээг хамарсан Агаарын чанарын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. Шахмал түлшний үйлдвэрийн стандартыг олон улсын түвшинд нийцүүлнэ.
- 5.18. Экосистемийн тэнцвэрт байдлын алдагдал, байгалийн нөөц баялгийн зүй бус ашиглалтыг зогсоох, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг дээшлүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдал, ногоон хөгжлийг ханган, хүний амьдралын чанарыг сайжруулна.

